

Хил орчмын хамтын ажиллагаа



1966 онд Горно-Алтайн Манжерок сууринд болсон Зовлолт, Монголын залуучууд, оюутны их наадмын 50 жилийн ойг ОХУ-ын Алтайн хязгаар болон Монголын олон нийт

ирэх 2016 онд хамтран тэмдэглэнэ. Онгорсон наймдугаар сард Улаанбаатар хотод Монголын Үндэсний их сургууль, Горно-Алтайн улсын их сургуулийн удирдлагууд, түүнчлэн хоёр улсын сэтгүүлчдийн байгууллага, “Ховдын толь” сонин болон Вестник Горно-Алтайска сонины удирдлагууд хамтран энэхүү үйл ажиллагааны хүрээнд Монгол Оросын залуучуудын чуулга уулзалтыг мон ирэх онд АБНУ-д зохион байгуулах тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан билээ. Уг хэлэлцээрт Ховд их сургууль болон Ховд аймаг, Монголын баруун бүсийн залуучууд оюутнууд ч хамрагдаж байгаа юм. Анхны энэхүү хуралдаанаар уг үйл ажиллагааг зохион байгуулах хамтарсан хорооны бүрэлдэхүүнийг сонгож, хариуцах ажлуудыг нь тодорхой болгосон бөгөөд одоо 1966 оны наймдугаар сард болсон тэрхүү мартагдашгүй өдрүүдийн тухай дурсамж, мэдээлэл, материалуудыг цуглуулан, эмхэтгэх ажил хийгдэж байна. Энэ тухай ном хэвлэгдэн гарах бөгөөд АБНУ-ын “Вестник Горно-Алтайска” сонины редакци олон жилийн өмнөх тэрхүү үйл явдалд оролцсон, мэдээлэл авч байсан бүхий л хүмүүсийг дурсамж, сэтгэгдэл, хадгалан үлдсэн хийгээд олж авсан мэдээллүүдээ хуваалцахыг урьж байгаа юм.

Тухайн үеийн Горно-Алтай хотын дунд сургуулийн бага ангийн сурагч би 1966 онд фестивал болох хүртэл Манжерок дахь Лениний нэрэмжит пионерийн лагерт гурван ч удаа амарчихаад байсан юм. Фестивал болдог жил би арвангурван настай жаалхүү байсан бөгөөд тэнд оролцсон олон хүмүүс, хийгээд үйл явдлыг харж, ой санаандаа хадгалсан маань одоо чухам үлгэр мэт санагдаж байна. Найрамдал – Энэ Манжерок /Дружба – это Манжерок

/

гэж дуулдаг нэгэн алдартай хэрнээ энгийн сайхан дууг олон хүн санаж байгаа. Жаран жил дуулагдсан энэ дуу

г

та ч гэсэн аялах дуртай бизээ.

Бүх холбоотын Лениний коммунист залуучуудын эвлэлийн тов хорооны /ЦТ ВЛКСМ/ захи алгаар Зовлолт Монголын оюутан залуучуудын их наадмыг ийнхүү тэмдэглэсэн тэр жил Улаанбаатар хотод Зовлолт, Монголын залуучуудын байгууллагын хооронд хамтран ажиллаж, харилцан туслалцах шинэ гэрээнд гарын үсэг зурсан тухай мэдээллүүд тухайн үеийн сонин хэвлэлд нийтлэгдсэн байдаг.

Алдарт Чуйн их зам дээрх Манжерок тосгоноос холгөвхэн Манжерок нууран дээр, мон Бийск, Барнаул Горно-Алтай хотуудыг хамруулан явагдсан тэрхүү их наадмын тухай цоонгуй мэдээлэл архивт хадгалагдаж үлджээ.

Их наадамд “Манжерок” дууны зохиогчид болох яруу найрагч Наум Олев, хөгжмийн

зохиолч Оскар Фельцман нар оролцож, эргээс нь дотогш 30 метрийн зайд нуурын мандал дээр зассан тайзан дээрээс бүх оролцогчдод хандан үг хэлж, дуу хоолойгоо оргож байв. Энэ бол 1966 оны 8 дугаар сард юм. Тэнд болсон үйл явдлын тухай Эдита Пьехагийн “Хох түүдэг” дуу цэнхэр дэлгэцээр олны хүртээл болж байсныг тэр үеийнхэн бүгд санаж байгаа байх. Түүнчлэн орон нутаг судлаач Николай Воробьевийн хэлснээр бол “Манжерок” дуу бараг хагас зууны турш хязгаар нутгийнхны бахархал болсоор ирснээс гадна эстрадын тайзан дээр үнэнхүү алдаршиж чаджээ.

Сэтгэлд тод үлдсэн бас нэг дурсамжыг сохоход нуурын мандлыг “чилим” буюу усны самар битүү бүрхсэн байсансан. Энэ ховор ургамлын ургаж, боловсрох үе нь нуурын ёроолд онгордог ба боловсорч гүйцээд ийнхүү мандал дээр цэцэглэн ховдог юм. Тухайн үеийн дүр зургийг харахад нуурын мандал олон мянган эвэртэй толгойнууд ховж байх шиг сэтгэгдэл торүүлж байлаа. Хязгаар нутгийн эртний хүмүүс түүнийг “чотгорийн самар” хэмээн нэрлэж, элдэв зүйлд ихээр хэрэглэдэг байсан ба улаан номонд орсон ховор ургамал юм. Сүүлийн үед энэтхэг, хятадад энэ ургамлыг тарималжуулан хэрэглэдэг болжээ.

Тэгэхэд фестивалд хоёр гурван сарын орноос бэлтгэж эхэлсэн юм. Тиймээс пионерийн лагерт хоёр, гуравдугаар улиралд хүүхдүүдийн ээлжийг цуцалж зовхон фестивалийн бэлтгэлд бүхнийг зориулж байсныг санаж байна. Фестивалын үеэр нуурын мандал дээр банз модоор үлэмж том талбайг эзэлсэн, хотхон байгуулж, нуурын ховоог орлохуйц элсэн тогол хүртэл гаргасан байв. Хэдий усны мандал дээр ч гэсэн тэнд 25 градус хүртэл зуны наран ээж, хүүхэд залууст гойд сэтгэгдэл торүүлж байсан юм. Тэнд бас В.И. Лениний нэрэмжит пионерийн лагерийг бий болгосон нь амарч тухлах хэсэг, хооллох газар, гар бомбог болон бусад спорт тоглоом тоглох стадион, урлагийн тогтлолт хийх тайз, үзэгчдийн танхим бүгдийг цогцлоожээ. Нэг үгээр хэлбэл өсвөр үеийнхний томоохон цогцолбор болсон байсансан.

Миний аав тэгэхэд Горно-Алтайскийн Зорчигч тээврийн газрын /АТХ/ буюу /ПАТП/ аж үйлдвэрийн тэргүүний ажилтан, хамгийн анхны том оврын автобус жолоодох эрхийг гардаж авсан байсан юм.

Аав маань Монголын оролцогч залуучууд, оюутнуудын түрүүч /ЗИС150/ маркийн ачааны машинаар Кош-Агачийн районы Ташантаар ирцгээж байгаатай хамгийн түрүүнд тааралдсанаа хэлж билээ. Гал долоор бадарсан ховгүүд охидыг харахад гайхалтай байсан хийгээд тэднийг шинэхэн ПАЗ автобусанд шилжин сууж замаа туулахыг санал болгожээ. Тэгээд Чуйн их замаар ийм 20 гаруй машин жингийн цуваа шиг цувран ходолсон гэдэг. Улаанбаатараас ирсэн Монголын залуучуудын дунд бяр хүчит бохчүүд,

мэргэн буудагчид, сур харваачид, Монголын ардын театрын авьяаслаг жvжигчид ч байлаа.

Москвагаас жvжигчин Сергей болон Кирилл Столяров, хогжмийн зохиолч Оскар Фельцман, дуучин Эдита Пьеха, акробат гимнастикч Геннадий Попов нар хvрэлцэн ирсэн. Тэд бvгдээр хамгийн эхний автобусаар ирсэн богоод дашрамд vгvвлэхэд Геннадий Попов бол Горно –Алтайн Ойрад угсааны хvн байлаа. Тэрээр Горний Алтай хотод торж, эндхийн Социалистуудын гудамжны хоёр давхар байшинд хvвхэд насаа онгороожээ.

“Манжерок гэж юу байдгийг манай найзад хэлж өгнө үү” хэмээн эгшиглэх тэр л дууны аялгуу их наадмын оролцогчдын сэтгэлд мартагдашгvй, гvнзгий сэтгэгдэл vлдээсэн юм. Мэдээжийн хэрэг Монголын ховгvвд охид энэ дууг сонсоод муухан ойлгож байсан ч дагаж дуулсаар “Манжерок -Дружба найрамдал” гэдэг vгийг хурдан хугацаанд, бvгдээрээ сурцгаасан юм. Энэ vг нэг ёсондоо их наадмын таних vг

/

парол

/

нь болж байлаа. .

Тэндэхийн иргэд, оршин суугчид нэг их товогвйгээр наадмын бvс буюу залуусын хотхонд зочилцгоох бололцоотой байсан санагдана. Оршин суугчид болоод Монголын оролцогч залуус танилцаж, нэр хаягаа ч солилцоцгоож байв.

Их наадмын нэгэн хvндэт оролцогч Геннадий Поповын vзvвлбэрvвд хvвхэд залуусын чухам цосийг хооргож байсан богоод хоёр пудийн жинтэй, /гир/ мон тvвнээс хэдэн хувь хvнд бомбологоор ээлжлvвлэн, ямарч хvч гаргахгvйгээр чолоотой жонглердэж, нэг гар дээрээ зогсож, таваас зургаан метрийн ондор дэх нарийн тросон дээгvвр бэхэлгээгvйгээр явж байсан нь гайхамшиг гэхээс аргагvй. Энэ гайхамшгуудыг vзvвлэгч маань vзvвлбэрийнхээ дараа инээмсэглэн, гарын vсгээ тvгээж байсныг санаж байна. Монголын ховгvвд тvвний уран чадварт ихэд татагдаж, буй нь илэрхий байлаа. Их наадмын хоёр дахь одор “Алтайн залуучууд”

/

Молодежь Алтая

/

сонинь шинэхэн дугаар уншигчдын гар дээр ирэхэд, сэтгvвлч Борис Майоровын бичсэн “Дуудлага” vгvвлэл нийтлэгдсэн байсан. Энэ vгvвлэлд их наадмын оролцогч Геннадий Поповтой хийсэн уулзалтын тухай, тvвний жинхэнэ гавьяат вйлсийн тухай нийтэлсэн байлаа. Энд vгvвлснээр Геннадий Попов бvх дэлхийн эв санааны нэгдлийн толоо анх

удаа Париж дахь Эйфелийн цамхагийн орой дээр ороосон гар дээрээ зогссон хийгээд түүний энэ амжилтыг одоог хүртэл хэн ч давтаж чадаагүйг хэлэх нь зов болов уу. Тэрхүү үгүүллийг хайчилан авсан сонины шаралсан хайчилбар одоо хүртэл суурингийн архивт хадгалагдаж үлджээ

Наадамд Монголоос ирсэн бохийн спортын тамирчид үлэмж хвчтэй байсан ба бохийн барилдааны үзүүлэх тоглолт нь маш сонирхолтой хийгээд амжилттай болсон юм. Монхүү буудлагын тэмцээнд оролцсон нэгэн мэргэн буудагчийн нэр алдрыг мэдэж чадаагүй нь харамсалтай. Тэр буудагч 50 метрийн зайнаас 10 удаа буудахдаа бүгдэд нь хамгийн дээд оноо авч хүмүүсийг бишрүүлж байв. Тэрээр энэ бол эх орны дайнд оролцон, тулалдаж байсан Горно-Алтайскийн нэгэн чолоонд гарсан дайчин байсан богоод дахин давтагдашгүй амжилтыг үзүүлсэн билээ. Монголоос ирсэн сур харваачид ч бас бахархам сайхан харваж, нумнаас тавьсан сум нь онох байгаа хүртэл шунганан нисэлдэж байсан нь онцгой сэтгэгдэл торvvлдэг юм. Тэдгээр харваачид бүгд л освор, залуучууд байсан болохоор асар туршлагажсан мастерууд очсон гэж хэлэх нь дэгс болох байх. Гэсэн ч бидэнд тийм хвчтэй сэтгэгдэл торvvлж байсныг бодоод жинэхэнэ мастеруудтай харьцуулбал чухам ямар байсныг яахин мэдэх.

Их наадмын талбарт одор бүр найрамдал, хайр энэрэл, эх орны сэдэвт аялгуут дуунууд эгшиглэж, үзэгчдийн талархалын мэдрэмжээр нэлэнхүйдээ гэрэлтэн, үзэгчдээс тэдэнд цэцгийн баглаагаар мялаалга оргосоор байсан. Зовлолтийн кино жүжигчин Сергей Столяров надад гарын үсгээ огсониог тодхон санаж байна. Харин Монголоос ирсэн сэтгүүлч Даян эцэгт маань пластинан металиар хийсэн шаргал онгийн дээлтэй хэн нэгэн хүний дүрс баримал бэлэглэсэн юм. Тэр баримлын ар талд нь “Сүхбаатар” гэсэн гарын үсэг байлаа. Дараа нь би Монголчуудтай танилцаж мэдэлцэх үедээ тэр бол ХХ зууны эхэн үед Монголчуудын хувьд чухам л жинэхэнэ будда бурхан байсныг мэддэг болсон юм. Энэ бэлэг бол монхийн найрамдлыг, түүний ивээгч тэнгэрийг бэлгэдсэн бэлгэдлийн гүн агуулгатай байсан юм билээ. Тэр одроос хойш яг 20 жилийн дараа 1986 онд надад Монголын Баян-Олгий аймагт очих завшаан тохиов. Тэнд би сэтгүүлч Даян гуайтай уулзаж энэ тухай дурсахад тэр бүгдийг санаж байсан богоод сэтгэл нь ходлон нулимс унагаж билээ. Гэвч би тэр хүнтэй хамгийн сүүлчийн удаа уулзаж байгаагаа тэр мочид яахин мэдэх билээ.

Тэр үед Зовлолт Монголын залуучууд оюутны фестивалд оролцсон Монгол андуудаас маань одоо Баян-Олгий аймагт хэн ч үлдсэнгүй нь үнэхээр тоогүй. Харин Ховд аймаг дахь “Ховдын толь” сонины редактор манай тvнш, эрхэм дvв Тормонхийн маань сурвалжилснаар одоо Ховдод 1966 оны наадамд оролцож байсан нэг, хоёрын зэрэг ахмад байгаа богоод тэдгээрийн дурсамж, сэтгэгдлийг сонсох, хэрвээ боломж байвал нvүр учрах завшаанийг би ихэд хvсэн хvлээж байна. Оноодор Манжерок нуурын эргээс холгvйхэн уулын цанын бааз байгуулагдан, аялал жуулчлалын цогцолбор бий болжээ.

Францын тослоор хийгдсэн энэ байгууламжийг бүтэн жилийн турш барьж байгуулсан юм. Замын дагууд оволд нь цанын бааз ажиллаж зунд нь амралт, жуулчлалын газрын үүд хаалга байнга нээлттэй байх юм. Чуйн их замаас нуурын суурин, нуур хүртэл дардан сайхан засмал зам тавигджээ. Тэнд далайн твшинээс 1228 метрийн ондорлогт бүхий Малая Синюха уулын оргил оод оргогч татлагаар дамжин гарч, Алтай дахь Артем Игнатенкогийн сүм болон олон зүйлийг дээрээс нь харж болно. Ижилгүй сайхан олон зүйл хуралдан тогтсон энэ нутагт жуулчдын бааз, орон байрнууд олноор бий болж, энэ цагийн нэгэн онцлогийг илтгэх, аяллын бизнес цэцэглэн хөгжиж байгаа юм.

Манжерок бол манай ард түмний Монголын ард түмэнтэй тогтоосон ахан дүүсэг, найрамдалт харилцааны жинхэнэ амьд түүх билээ.Â

Алексей Ивашкин

Орос хэлнээс орчуулсан Г.Төрмөнх

Зургийн тайлбар: Оросын нэрт дуучин **Эдита Пьеха** 1960 он.

“Молодежь Алтая” сонины 1966 оны дугаарын хайчилбар, зохиогчын хувийн архиваас.